

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 08 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 08 дугаар сарын 09

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар НЭГ: Нийслэлийн бүх шатны байгууллагууд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангаж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, чанарт онцгой анхаарч, Захирагчийн ажлын алба хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. (Нийт байгууллагууд)				
1.	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/853 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Чингэлтэй дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсэг дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/253 дугаар захирамжаар байгуулагдсан.</p> <p>Тус захирамжийн дагуу өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын явцын тайлан, мэдээг сар бүрийн 30-ны өдрийн дотор харьяа хэлтэс албадаас авч нэгтгэн тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын ханган сайжруулсан шахмал түлш нөөцлөх агуулахын судалгаа авч нэгтгэн нийт 10-н хорооны 41 байршилд нөөцлөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Хөрөнгө оруулалтын ажлуудын явцын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 17 дугаар хорооны Сурагчийн 24-р гудамж авто зам, чулуун зам тавих", "Гудамж сайжруулах -11, 12, 14, 15, 16, 19", "Бага хэмжээний авто зам, чулуун зам тавих" ажлууд 100%-н гүйцэтгэлтэй дууссаныг хүлээж авсан. "Хорооны доторх авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/"-ажлын гүйцэтгэл 80%, "Хорооллын доторх авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 15 дугаар хороо/", "Гудамжны тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 14 дүгээр хороо/" -ажлуудын гүйцэтгэл 100%, "138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэг явах авто зам /ЧД, 12 дугаар хороо/" -ажлын газар шорооны ажил хийгдэж дууссан, авто болон явган замын хашлага тавигдсан, ажлын гүйцэтгэл 35 %-тай байна. /Газар чөлөөлөлттэй холбоотой ажил удааширч байна./</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар ХОЁР: Хөдөлгөөний ачаалал ихсэж байгаатай холбогдуулан авто зам, явган хүний гарцын гэрэл дохио болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангаж, урсгал засварын ажлуудыг эрчимжүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах. (Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Замын хөдөлгөөн удирдлагын төв,)				
2.	Чингэлтэй дүүргийн 5-р сургуулийн баруун хойд хэсэгт хорооллын эхлэл, төгсгөл тэмдгийг 2 ширхгийг байрлуулж ажиллалаа. Дүүргийн 4 –р хороо Ж.Самбуугийн гудамж, Хүнсний 1-р	=	Үүрэг даалгаврын	90

	<p>дэлгүүрийн уулзвараас зүүн тийш "Чингисийн музей"-н уулзвар хүртэл 300 метр замын асфальтан хучилтыг шинэчлэн, хэвтээ тэмдэглэлийг хэвийн ажиллагаанд оруулсан. 2022-2023 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан хийгдэх зам, явган зорчигчийн гарц, гэрлэн дохио, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.</p> <p>Дүүргийн хэмжээнд гэрэлтүүлэг ашиглагч "Соён дрийм" ХХК-тай хамтран нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн үзлэг шалгалтын ажлыг сард 1 удаа тогтмол хийдэг. Шалгалтаар 07 дугаар сард нийт 8 байршлын 18 гэрэлтүүлэг унтарсныг тухайн бүр мэдэгдэн засварлан ажиллалаа. /гэрэлтүүлгийн толгой, кабел шинэчлэх, ил гарсан утсыг засварлах зэрэг ажлууд хийгдэж байна./ ТНААХ</p>		хэрэгжилт хангагдана	
<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Нийслэлийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламж, халаалтын зуух, инженерийн шугам сүлжээнд хийгдэх их, урсгал засварын ажлуудыг эрчимжүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах. (Нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Засаг дарга нар,)</p>				
3.	<p>Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Төв салбар болон Бага тойруу салбарын халаалтын шугамын гадна болон узелийн хоолойг засварлаж, баталгаажуулан лацадсан. Эрүүл мэндийн төвийн цахилгаан 220-вт-ийн пускатель болон Бага тойруу салбарын цахилгааны шийтний 380-вт-ийн холболтын засварыг УБЦТС-ийн Зүүн түгээх салбартай хамтран шинэчилж дууссан.</p> <p>Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн нийт 20 сургууль, 39 цэцэрлэгүүдэд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 4 дүгээр хорооны 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажил хийгдэж байна. Дулааны холболт 100% ✓ 12 дугаар хороонд шинээр баригдаж байгаа 144 дүгээр бага сургууль, 276 дугаар цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил хийгдэж байна. Агааржуулалтын системийн ажил 95%, дулаан, сантехникийн ажил 100%, гадна цэвэр, бохир шугамын ажил 100%-н гүйцэтгэлтэй. ✓ 19 дүгээр хороонд баригдаж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажлын сантехникийн ажил 90%-н гүйцэтгэлтэй байна. ✓ 5 дугаар хороонд баригдаж байгаа шинэ цэцэрлэгийн сантехникийн ажил 100% бүрэн хийгдэж дууссан. ✓ 1 дүгээр хороонд шинээр баригдаж байгаа 39 дүгээр цэцэрлэгийн ажлын явц 95%-тай, шугам сүлжээний ажил 100% хийгдсэн. ✓ 24 дүгээр сургуулийн гадна 80м цэвэр, бохир усны шугам солих ажлыг "Грэйт Майнинг" ХХК 100%-н гүйцэтгэлтэй бүрэн дуусгасан. <p>Дүүргийн 61 дүгээр сургуулийн гадна талбайн 200м хөрсний ус зайлуулах шугам хоолойн угсралтын ажлыг Геодези усны барилга байгууламжийн газар 100% гүйцэтгэсэн. Тус сургуулийн тохижилт, нөхөн сэргээх ажил хийгдэж, дотор сантехникийн 30 метр шугам засварын ажлыг "Эхийн ачлал үрд" ХХК 100%-н гүйцэтгэлтэй сольж дуусгасан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 8 дугаар сараас эхлэн сар бүр Засгийн газарт тайлагнаж байгаатай холбогдуулан Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах. (Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд)			
4.	Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны 8 дугаар сараас эхлэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг сар бүр тайлагнаж ажиллахтай холбоотой дээд газраас чиглэл ирээгүй байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана 30
Үүрэг, даалгавар ТАВ: Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа хяналтын инженер, холбогдох албан хаагчид гүйцэтгэлийн явцын мэдээллийг /Хөрөнгө оруулалтын ажлын бүртгэл мэдээллийн цахим системд/ тогтмол бүртгэж ажиллах. (Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд)			
5.	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 03/3793 тоот албан бичгийн дагуу (www.investpro.gov.mn) цахим системд нэвтрэх эрх бүхий албан хаагчийн мэдээллийг itgel9887@gmail.com хаягаар хүргүүлсэн бөгөөд 2022.08.10-ны өдрийн байдлаар баталгаажуулаагүй байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана 30
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон үерийн далан сувгийн хог хаягдлыг сайтар цэвэрлэх, засвар шинэчлэл ажлуудаа эрчимжүүлж ажиллах. (Дүүргийн Засаг дарга нар, Хот тохижилтын газар, Геодези, усны барилга байгууламжийн газар)			
6	<p>Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ууд иргэдийн бүлгийг өөрсдийн хөрөнгөөр тогтмол ажиллуулж байна. Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлэг, “Найши трейд” ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 13 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлгийг тогтмол ажиллуулж байна. Дээрх 2 компани дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд 30 хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлгийг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгүүлж байна. Цэвэрлэгээний явцад гэр хорооллын гуу жалга, далан сувгийн үүсмэл хог хаягдал, шарилж болон лаг цэвэрлэгээг цэвэрлэж байна. Цэвэрлэгээний явцад нийт 45232 м2 талбайн 109,2 тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж ачилт хийсэн.</p> <p>Дүүргийн 8, 12, 15 дугаар хороодын нутаг дэвсгэр дэх борооны усанд их хэмжээгээр эвдэрсэн үерийн хамгаалалтын далан, сувгуудыг яаралтай засварлуулах хүсэлтийг Геодези, усны барилга байгууламжийн газарт албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон үерийн далан сувгийн хог хаягдлыг сайтар цэвэрлэх, засвар шинэчлэл ажлын хүрээнд дүүргийн 1-20, 24 дүгээр хороод Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан 2022 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” А/08 дугаартай тушаалын дагуу 37 СӨХ, 307 ААНБ, 665 иргэнийг хамруулан үүрэг чиглэлийг өгч гүйцэтгүүлсэн.</p> <p>ХХҮХ-тэй хамтран “Нийтийг хамарсан ажил” төсөлд хамруулан 40 ажил орлогогүй иргэнээр цэвэрлэгээний ажлыг гүйцэтгүүлэн урамшуулал олгосон.</p> <p>Хороо тус бүр цахим “фэйсбүүк”, “пейж” хуудсаар дамжуулан цаг үеийн мэдээ, мэдээлэл, их цэвэрлэгээ, засвар шинэчлэлийн ажлын зохион байгуулалтын талаар иргэдэд мэдээлж ажиллалаа.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана 90

Үүрэг, даалгавар ДОЛОО: Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цахилгааны ил гарсан утас, ухсан нүх, явган хүний замын тэмдэглэгээ, орц гарц, сургууль орчмын хурд сааруулагчийг засаж сайжруулах, стандартад нийцүүлэх, хүүхдийн тоглоомын талбайг засаж сэлбэх, эзэнгүй нохой, мууранд хазуулахаас урьдчилан сэргийлэх ажлуудыг эрчимжүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах. (Захирагчийн ажлын алба, Замын хөгжлийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Хотын стандарт, хяналтын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дүүрэг, хорооны Засаг дарга нар)

7	<p>Дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлийн нэгдүгээр хуралдааны шийдвэрээр нийтийн эзэмшлийн талбай болон сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад болон дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадыг хороодын нутаг дэвсгэрт дэх нийтийн эзэмшлийн талбай, сургууль, цэцэрлэгийн орчинд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж ажиллах хуваарийг дүүргийн Засаг дарга 2022.03.28-ны өдөр батлан, батлагдсан хуваарийг Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 3/598, 3/599 дугаарын албан бичгээр нийт 27 байгууллагад хүргүүлсэн.</p> <p>Хичээлийн шинэ жилийн 2022-2023 оны бэлтгэл ажлыг хангах хүрээнд Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу хариуцсан хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн талбай, сургууль, цэцэрлэгийн орчинд батлагдсан хуваарийн дагуу хяналт, шалгалт хийсэн ажлын тайланг нэгтгэн 24-н ЕБС, 42 цэцэрлэг, хороодын гадна байрлах тоглоомын талбай, орон сууцны дундах тоглоомын талбай зэрэг нийт 140 байршлын тоглоомын талбайг холбогдох байгууллагуудтай хамтран шалгаж, илэрсэн 24 зөрчлийг үе шаттайгаар арилгуулан ажиллаж байна.</p> <p>Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн хэмжээнд нохой устгалын ажлыг Улаанбаатар хотыг Захирагчийн ажлын албаны гэрээт “Их булаг”, “Өлтэй” ХХК-тай хамтран 07 дугаар сард нийт 7-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт иргэдийн дуудлагын дагуу эзэнгүй золбин 79 нохойг устгалд орууллаа.</p> <p>Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн арчлалт хамгаалалттай Чингэлтэй дүүргийн “Тохижилт Үйлчилгээ” ХХК- хамтран үзлэг шалгалт зохион байгуулсан. Шалгалтаар нийт 65 бичил цэцэрлэг, тоглоомын талбайн 8 байршилд 15 засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. (Резин хавтан шинэчлэх, эвдэрсэн хайсыг янзлах, сагсны талбай сэргээж будах, хогийн сав засварлах)</p> <p>Дүүргийн 4 дүгээр хороо, Замын цагдаагийн хэлтэстэй хамтран 5 дугаар сургуулийн урд талын авто замын хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулан, өнгө будгийг сэргээн засварласан. Мөн сургуулийн баруун талын туслах авто замын хурд сааруулагч замын тэмдэг тэмдэглэгээг янзлах, сургуулийн өмнөх боловсролын 4,9,18,37 дугаар цэцэрлэгүүдийн гадна орчны авто зам, явган гарцын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, өнгө будгийг сэргээх, хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлж ажиллах талаар албан мэдэгдлийг хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн 6 дугаар хороо 35 дугаар байр, 33/А байрны дулааны шугам задарч засварын ажлын хүрээнд ухсан нүхийг бөглүүлэх талаар ОСНААУГ-т мэдэгдэж зөрчлийг арилгуулан ажиллалаа.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
---	--	---	---------------------------------------	----

	<p>Дүүргийн 9 дүгээр хорооны иргэний танхим, мэдээлэл хүргэх бүлгэмээр нийт иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, эзэнгүй муур нохойд хазуулахаас сэргийлэх санамж сэрэмжлүүлгийг хашаандаа нохойтой өрхүүдэд хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн 12 дугаар хорооны урд уулзвараас 32-н тойрон хүртэлх зам дагуу үерийн усны сувгийг Геодези усны барилга байгууламжийн газартай (ОНӨААТҮГ) хамтран 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс 08 дугаар сарын 09-ний өдөр хүртэл хөрсний ус зайлуулах, далан сувгийг цэвэрлэн, лаг хагшаасыг төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.</p> <p>Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Нийгмийн даатгалын тасаг зэрэг байгууллагуудын хөдөлгөөний ачаалал ихтэйгээс түгжрэл үүсэн ЕБ-ын 17 дугаар сургуулийн орчинд хүүхдийн эрүүл аюулгүй байдал алдагдан, осол гэмтэлд өртөх эрсдэл үүсэхээс сэргийлэх зорилгоор тус хороонд үйл ажиллагаа явуулдаг "Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сүм"-ийн авто зогсоолд дээрх 2 байгууллагын ажилтан, албан хаагчдын авто машиныг түр байршуулж хэвшсэн.</p> <p>Дүүргийн 17 дугаар хорооны Зүрх-Уулын 4 дүгээр гудамжинд байрлах "Олон булагтайн цэцэрлэгт хүрээлэн"-д эрсдэлтэй хагарч эвдэрсэн, засварлах боломжгүй тоглоомуудыг дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК-д мэдэгдэн буулгууллаа.</p> <p>Сурагчийн 61 дүгээр гудамжинд байрлах хүүхдийн тоглоомын талбайг хариуцсан "Гарден сити" компани хөрснөөс сул эрсдэлтэй байгаа тоглоомуудыг хөрсөнд бэхлэх, таримал модны арчилгааг хийлээ.</p>			
<p>Үүрэг, даалгавар НАЙМ: Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа төлөвлөгөө батлагдсан тул нийт байгууллагууд хэрэгжилтийг хангаж, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас эмнэлгийн үндсэн тусламж, үйлчилгээг сайтар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. (Нийт байгууллагууд)</p>				
8	<p>НЭМГ-ын коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Коронавируст халдвар (Ковид-19)-ийн дуудлага мэдээлэл авдаг 88250534 дугаарын утас, шуурхай хариу арга хэмжээний 2 баг 24 цагаар ажиллаж Ковид-19 халдвартай иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. • "Ковид-19" шинжилгээний цэг Даваа гаригаас Ням гаригт 09-12 цагийн хооронд ажиллаж, иргэдээс түргэвчилсэн болон, ПГУ шинжилгээг хийж байна. • Дүүргийн ЭМТ-ийн "Хайлааст хүүхдийн амбулатори"-д 2022.07.24-ний өдрөөс дүүргийн ЭМТ эмнэлгийн хашаанд явуулын (зөөврийн байр) "Ковид-19" амбулаторийн үйл ажиллагааг эхлүүлсэн. "Ковид-19" амбулатори нь ажлын өдөр 09:00-20:00 цагт, Бямба, Ням амралтын өдөр 10:00-15:00 цагийн хооронд ажиллаж байна. • ӨЭМТ-үүд ажлын өдрүүдэд 09:00-20:00 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна. • ЭМЯ-наас гаргасан "Ковид-19" цар тахлын үеийн ор дэлгэх төлөвлөгөөний дагуу дүүргийн "Ковид-19" халдвартай иргэдийг БГД-ийн Нэгдсэн эмнэлэг дэх 150 ортой "Ковид-19"-н эмнэлэг болон ЭМЯ-ны ор зохицуулах багаас хуваарилсан бусад эмнэлэгт тээвэрлэн хүргүүлж хэвтүүлэн эмчлүүлж байна. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70

ЭМТ-ийн ПГУ лабораторийн үйл ажиллагааг 2022.07.25-ны өдрөөс эхлүүлж, эмч, эмнэлгийн ажилтан, албан хаагчдыг урвалж оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис зэрэг шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллаж байна.			
--	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

М.НАВЧАА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ